

2025 оны 01 сарын 06-ны өдөр

№ 2025/1

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягт 31,200,000 (гучин нэгэн сая хоёр зуун мянга) төгрөгийн зээлийг дараах нөхцөлөөр олгохыг зөвшөөрсүгэй.

Зээлийн хүү	28.8% /жилийн /
Зээлийн хугацаа	24 сар
Зээл олголтын шимтгэл	1%
Эргэн төлөх нөхцөл	Сар бүр үндсэн зээл, хүүгийн хамт
Зээлийн зориулалт	Мотоцикл худалдан авах

2. Зээлийн гэрээ байгуулсантай холбогдуулан худалдан авсан Royal Enfield Himalayan 450 маркын 2 мотоциклыг барьцаалж барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т олгосугай.
4. Энэхүү санал хураалтад Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ